



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 03 сарын 18 өдөр

Дугаар А/199

Булган сум

“Төрийн цэргийн болон, Хууль сахиулах
байгууллага, Хууль зүйн салбар”-ын эмэгтэйчүүдийн
нэгдсэн чуулга уулзалтад дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4 дэх заалт, аймгийн Засаг даргын 2025 оны А/377 дугаар захирамжаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгөөс тусламж, дэмжлэг олгоход баримтлах журам”-ын 5.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Харилцан хүндэтгэе” уриа дор зохион байгуулагдаж буй “Төрийн цэргийн болон, Хууль сахиулах байгууллага, Хууль зүйн салбар”-ын эмэгтэйчүүдийн нэгдсэн чуулга уулзалт зохион байгуулахад 3,000,000 (гурван сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх дэмжлэгийг Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР